



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 52

Сүхбаатар сум

Бэлчээрийн газрын төлбөрийн талаар  
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “д”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” 131 дүгээр тогтоол, “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 182 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Бэлчээр хадлангийн талбайн доройтлыг бууруулах хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдээс 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн жил бүр нэг хонин толгойд ногдуулах бэлчээрийн газрын төлбөрийг тухайн газрын тогтоосон суурь үнэлгээний 0.03 хувиар ноогдуулан авсугай.

Хоёр. Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь заалтыг хэрэгжүүлэн нутаг дэвсгэртээ бэлчээрийн газрыг ашиглуулахтай холбогдсон журмыг боловсруулан батлахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үүрэг болгссугай.

Гурав. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэн бэлчээр ашигласны төлбөрийг бэлчээр хадлангийн талбайг нөхөн сэргээх, ашиглалтыг сайжруулах, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зэрэг ажил арга хэмжээнд зарцуулахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГА  Г.ВЯМБАА

